

**БАТЛАВ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, “ИРГЭДИЙН ОРОЛЦОО II” ТӨСЛИЙН ЗАХИРАЛ**



**Г.БИЛГҮҮН**

**ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЛИЙН КАМПАНИТ АЖИЛ-2 ЗОХИОН  
БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

**2019.08.30**

**А. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Засгийн газар, Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хэрэгжиж буй “Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр”-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо II” төсөл нь иргэдийн оролцооны хууль, эрх зүйн орчныг сайжруулах, олон нийтэд иргэний оролцооны хууль, эрх зүйн мэдлэг олгох үйл ажиллагааг дэмжих зорилттойгоор ажиллаж байна.

**Б. ЗОРИЛГО**

Энэхүү ажлын зорилго нь иргэний оролцооны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, иргэдийг оролцооны тодорхой үйл ажиллагаанд сэдэлжүүлэх зорилготой.

**В. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ ҮҮРЭГ**

Гүйцэтгэгч нь олон нийтэд зориулж тодорхой сэдвийн хүрээнд дараахь ажил, үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Иргэдийн оролцооны хуулийн зохицуулалтаас амьдралд хамгийн түгээмэл хэрэглэх боломжтой сэдэв, кейсийг сонгох талаар төслийн нэгжтэй хамтран зөвлөлдөж төлөвлөх;
- Иргэдийн оролцоо төслийн үйл ажиллагаа, холбогдох судалгаа, дүн шинжилгээтэй танилцах, энэхүү кампанит ажлыг бусад олон нийттэй харилцах ажлуудтай уялдуулах;
- Иргэний оролцооны сайн туршлагыг харуулсан баримтат нэвтрүүлэг букуу түүхээр таниулсан 8-15 минутын видео шторк 5 ш бэлтгэх;
- Видео бүтээлийг телевиз, сошиалд сурталчилахад зориулсан 1-2 янзаар /урт, богино/ бэлтгэх,

- Контентын сэдвээр сошиалд түгээх 24 ширхэг /Нэг видео 3 постер/ постер бэлтгэх /Хүний хэлсэн үг, тоон мэдээлэл, инфографик гэх мэт/, олон нийтэд инстаграм, твиттер, фэйсбүүкээр түгээх,
- Бэлтгэсэн бүртээгдэхүүнийг сошиалаар түгээх идэвхжүүлэлт /Boost/-ийн төсөв хамгийн багадаа 300 ам.доллар байх.

Төслийн нэгж нь гүйцэтгэгчийг холбогдох мэдээллээр хангана.

### **Г. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА**

Дээрх ажлыг гүйцэтгэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Контент, маркетинг, видео бүтээлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага байх,
- Мэргэжлийн техник, тоног төхөөрөмжийн нөөцтэй байх,
- Сүүлийн 2 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх,
- Багаар ажиллах чадвартай, мэргэжлийн хамт олон байх,
- Хөдөө орон нутагт ажиллах боломжтой байх,
- Нийгэмд чиглэсэн, асуудал хөндсөн үйл ажиллагаа явуулж байсан, адил төстэй бүтээл хийж байсан туршлагатай бол давуу тал болно.

### **Д.ХУГАЦАА**

Гэрээт ажлыг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хуанлийн 60 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

### **Е.ТӨСӨВТ ӨРТӨГ**

Төсөвт өртөгт 12 000 000 /Арван хоёр сая/ төгрөг байх ба Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу аливаа татвар, шимтгэл энэ үнийн дүнд багтсан болно. Ажил гүйцэтгэх гэрээнд 2 тал харилцан гарын үсэг зурсны дараа ажлын 5 хоногийн дотор гэрээний үнийн дүнгийн 40 хувийг, Захиалагч тал гэрээнд заасан ажлыг хангалттай хэмээн хүлээн авсны дараа үлдэгдэл 60 хувийн төлбөрийг шилжүүлнэ.

### **Ё.ТАЙЛАГНАХ**

Захиалагч тал эцсийн тайланг хангалттай хэмээн хүлээн авч, ажил хүлээн авах актад гарын үсэг зурж баталгаажуулснаар ажил гүйцэтгэх гэрээ дуусгавар болно.

### **Ж. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

Ажил гүйцэтгэгч нь дараахь материалыг бүрдүүлэн, тус тусад нь дугтуйлж, “Иргэдийн оролцоо II” төслийн нэгжид хаяглан хүргүүлнэ.

Техникийн саналыг тусад нь дугтуйлан ирүүлнэ. Үүнд:

- Ажлын даалгаварт заасан ажлыг зохион байгуулах чадамжтайг баталсан байгууллагын танилцуулга, хүний нөөц, техник технологийн мэдээлэл,
- Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын хэрэгжилт, үр дүнгийн танилцуулга,
- Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө

Санхүүгийн саналыг тусад нь дугтуйлан ирүүлнэ. Үүнд:

- Үйл ажиллагааны санхүүгийн задаргаа,
- Нийт үнийн санал.

**Захиалагчийн хаяг:** “Иргэдийн оролцоо II” төслийн нэгж

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуульчдын гудамж 1, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар 14201, Монгол Улс

Утас: +976-70008688

Цахим шуудан. [tuguldurzaya@legalinstitute.mn](mailto:tuguldurzaya@legalinstitute.mn)